# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

┌"Түшиг даатгал" ХХК-д санхүүгийн даатгалын ┐
хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 3.23 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. "Түшиг даатгал" ХХК-д санхүүгийн даатгалын /1.11/ хэлбэрээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, "Түшиг даатгал" ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН